

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, МОНГОЛ-ОРОСЫН ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ДАРГА Д.ИДЭВХТЭНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Хатагтай ноёдоо, та бүхэнд Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг гэж нэрлэж байсан одоо Соёлоор харилцах Монголын нийгэмлэгийн үүсч байгуулагдсаны 60 жилийн ойн баярын мэнд хүргэж, өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний бага хуралд амжилт хүсч байна. Хоёр орон, хөрш зэргэлдээ орон олон жилийн найрсаг харилцаатай, энэ харилцаа цаашид үргэлжлэх болно гэдэг нь ойлгомжтой. 90 оноос хойш арваад жилийн хугацаанд хоёр улс өөр өөрийн асуудлаа дотооддоо шийдэх гэж бие биендээ анхаарал тавих нь багасч байсан ийм үе бий. Энэ үеийг бид гэтэлж гараад харилцаагаа улам өргөн болгох ийм замдаа ороод явж байна. Үүнийг олон жишээгээр баталж дурьдаж болно. Өндөр дээд хэмжээний уулзалтууд тогтмолжиллоо, бас одоо сүүлийн 10 хоногийн жишээгээр л гэхэд ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга ноён Сергей Михайлович Миронов мөн Монголд айлчиллаа, бас Төрийн Дум дахь Орос-Монголын парламентын бүлгийн 6 депутат Монголд айлчлаж хоёр улсын хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлэлцээр, өргөн хэлэлцүүлэг ярилцлага явууллаа, үүнд Монголын бизнесүүд, Оросын бизнесүүд оролцлоо, бас Монгол-Оросын хил галийн байгууллага, энэ хоёр улсын харилцаатай холбогдсон төлөөлөгчид, Оросын бүс нутгийн хүмүүс, төлөөллүүд оролцсон сайхан ярилцлага боллоо. Өнөөдөр гэхэд энэ байгууллагын 60 жилийн ойд Москвагаас, Новосибирскээс гэх мэтчлэн Монголтой харилцдаг бүс нутгуудаас бидний дотны нөхдүүд маань хүрэлцэн ирж байна, энэ бүгд бол хоёр улсын харилцаа улам өргөжиж, шинэ агуулгаар баяжиж байгаагийн тодрхой шижээ гэж хэлж болно. Монголын парламентад хамгийн хүчирхэг, хамгийн олон гишүүнтэй бүлэг бол Монгол-Оросын парламентын бүлэг байгаа, парламентын 76 гишүүний 45 нь Монгол-Оросын парламентын бүлэгт ордог, энэ бол хоёр улсын харилцаанд үнэхээр ач холбогдол өгч байгаагийн тодорхой жишээ юм. Энэ бүлгийн даргаар би ажиллаж байгаадаа их бахархаж энэ ажлыг цаашид улам сайн явуулах юмсан гэж чармайж байдаг. Сүүлийн 2 жилд манай парламентын бүлэг хоёр талдаа Москвад, Улаанбаатарт, Кызилд, Улан-Үдэд нийтдээ 50 удаа уулзаж ажил хэргээ ярилцсан байгаа, энэ бол харилцаа шинэ агуулгаар баяжиж гүнзгийрч байгаагийн тодорхой жишээ гэж ингэж бодож байна.

Ингээд та бүхэнд Монгол Улсын Их Хурал дахь Монгол-Оросын парламентын бүлгийн 45 гишүүнийхээ нэрийн өмнөөс энэ олон нийтийн байгууллага-МОКС үүсч байгуулагдсаны 60 жилийн ойн баярт зориулж баярын мэнд дэвшүүлж сайн сайхан бүхнийг хүсэж ерөөж байна. Өнөөдрийн олон улсын онол практикийн бага хуралд амжилт хүсэж байна, анхаарал тавьсанд баярлалаа.